



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2023 оны 01 дугаар сарын 27

№ 04/06

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
ТАНАА

“Бодлогод залуусын хяналт” НҮТББ-аас “Судалгаа хийх зорилгоор Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын эцсийн тайланг бүрэн эхээр нь авах хүсэлтийг Үндэсний Аудитын газарт гаргасан боловч холбогдох хуулиудыг буруу тайлбарлан, нийтэд нээлттэй байлгах мэдээллийг гаргаж өгөхөөс удаа дараа татгалзаж, олон нийтийн мэдэх эрхийг зөрчсөн” гэх гомдлыг Комисст гаргажээ.

Нэг. Үйл баримт

Гомдлын дагуу талуудаас тайлбар, баримт гаргуулан авч, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. “Бодлогод залуусын хяналт” НҮТББ-аас судалгааны зорилгоор Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг авах хүсэлтийг 2021, 2022 онд танай байгууллагад удаа дараа гаргасан байна. Хүсэлтийн дагуу Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч, тэргүүлэх аудитор [redacted] 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/2443 дугаар албан бичгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан болон хуулийн этгээд, иргэний хандивын жагсаалтыг хүргүүлсэн байна. 39 хуудас бүхий энэ материалд дүгнэлт, сонгуульд оролцсон нам, эвслийн орлогын тайлангийн нэгтгэл (Хавсралт 1), зардлын тайлангийн нэгтгэл (Хавсралт 2), 2.0 саяас дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт (Хавсралт 3), 1.0, 2.0, 3.0 саяас дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалт (Хавсралт 4) багтжээ.

2. “Бодлогод залуусын хяналт” НҮТББ-д хүргүүлсэн материалыг хангалтгүй гэж үзээд Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг бүрэн эхээр нь авах хүсэлтийг Танд 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр гаргахад Хувь хүний нууцын тухай хуульд заасан нууц мэдээлэл болох нам, эвсэлд хандив өгсөн иргэдийн мэдээллийг өгөх боломжгүй тул сонгуулийн зардлын тайланг улс төрийн намуудад хандаж, эх хувиар нь гаргуулж авахыг “Бодлогод залуусын хяналт” НҮТББ-т зөвлөсөн байна. Түүнчлэн, Төрийн аудитийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт “Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ” гэж, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх хэсэгт “хүний хувийн мэдээлэл” гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр,

D:\2023 on\A4.month1.docx

150060033

төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг” гэж заасныг тус тус үндэслэн, Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль, Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын эцсийн тайлангийн бүрэн хуулбарыг “Бодлогод залуусын хяналт” НҮТББ-д хүргүүлэх боломжгүй болохыг Комисст тайлбарлажээ.

3. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг танай байгууллагаас хуульд заасны дагуу хянан баталгаажуулж, цахим хуудаастаа байршуулжээ. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт заасны дагуу сонгуулийн зардлын тайланд дансны орлого, зарлагын тайлан бүрэн тусгагдана. Танай цахим хуудсанд нийтэлсэн дээрх хоёр тайлангийн нэгдүгээр хавсралтад орлогын, хоёрдугаар хавсралтад зарлагын мэдээллийг нийтэлсэн байх бөгөөд ингэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын хавсралт найм ба есдүгээр маягтад тусгасан дараах мэдээлэл багтаагүй байна. Үүнд:

а/ “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан”-д 1 дэх хавсралтаар оруулсан “Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт”-д холбогдох нам, эвслийн нийт 606 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны гүйлгээ тус бүрээр хийсэн орлогын дэлгэрэнгүй тайланд ил болгоогүй мэдээлэл:

- Баримтын огноо, нэр, дугаар
- Харилцагчийн нэр
- Гүйлгээний утга
- “Иргэний өгсөн нийт хандив” ангиллын
 - o Мөнгөн хандив
 - o Мөнгөн бус хандив
- “Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив” ангиллын
 - o Мөнгөн хандив
 - o Мөнгөн бус хандив
- “Хандивын дансаар орсон бусад орлогын гүйлгээ” ангиллын
 - o Нам, эвсэл, нэр дэвшигчийн хооронд шилжүүлсэн орлого
 - o Банкны үйлчилгээ
 - o Бусад

б/ “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан”-д 2 дахь хавсралтаар оруулсан “Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалт”-д холбогдох нам, эвслийн нийт 606 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны гүйлгээ тус бүрээр хийсэн зарлагын дэлгэрэнгүй тайлан дахь дараах мэдээллийг ил болгоогүй байна. Үүнд:

- Баримтын огноо, нэр, дугаар
- Харилцагчийн нэр
- Гүйлгээний утга

- “Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах” ангиллын
 - o “Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал”,
 - o “Сонгуулийн сурталчилгааны материал тараах зардал” хэсэг
- “Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал” ангиллын
 - o Ухуулах байрны түрээсийн зардал
 - o Нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал
 - o Нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал
 - o Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал
- “Цахим орчин ашиглах зардал” ангиллын
 - o Нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн тус бүр нэг цахим хуудаст шаардагдах зардал
 - o Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудаст шаардагдах зардал
 - o Бусад цахим хуудсыг сурталчилгаанд ашиглах нам, эвсэл болон нэр дэвшигчийн зардал.

в/ “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан”-д 1 дэх хавсралтаар оруулсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн орлогын тайлангийн нэгтгэл”, 2 дахь хавсралтаар оруулсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлангийн нэгтгэл”-д дараах мэдээллийг ил болгоогүй байна. Үүнд:

- Баримтын огноо, нэр, дугаар
- Харилцагчийн нэр
- Гүйлгээний утга
- Хандивын дансаар орсон бусад орлогын гүйлгээ /нам, эвсэл, нэр дэвшигчийн хооронд шилжүүлсэн орлого, банкны үйлчилгээ, бусад/
- “Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал” ангиллын
 - o цалин хөлс, урамшууллын зардал
 - o томилолтын зардал
 - o сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал
- “Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах” ангиллын
 - o сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал
 - o сонгуулийн сурталчилгааны материал тараах, хүргэх зардал
- “Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал” ангиллын
 - o эх бэлтгэлийн зардал
 - o нэвтрүүлгийн зардал.

4. “Бодлогод залуусын хяналт” НҮТББ нь хүмүүнлэг нийгмийг хөгжүүлэх, хувь хүний эрх, ардчилалын үнэт зүйлсийн талаар мэдлэгийг нэмэгдүүлэх дүрмийн зорилгын хүрээнд судалгаа, шинжилгээ хийх, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага байх бөгөөд сонгуулийн ил тод байдлыг үнэлэх судалгаа, мониторингийн ажлыг тогтмол явуулж байна. “Бодлогод залуусын хяналт” НҮТББ-т танай байгууллагаас хүргүүлсэн 39 хуудас бүхий материал (Сонгуульд оролцсон нам, эвслийн орлогын тайлангийн нэгтгэл, зардлын тайлангийн нэгтгэл, 2.0 саяас дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт, 1.0, 2.0, 3.0 саяас дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалт), цахим хуудаст нийтэлсэн аудитын дүгнэлтэд хавсаргасан материалаас сонгуулийн санхүүжилт хэрхэн бүрдсэн, ямар хүн, байгууллагаас ямар төрлийн үйлчилгээг хэдийд авсан зэрэг сонгуулийн үйл явц шударга, хуулийн дагуу өргөсөн эсэх,

санхүүжилтийг зохих ёсоор зарцуулсан эсэхэд дүгнэлт өгөхөд шаардлагатай мэдээллийг олж авах боломжгүй байна.

Хоёр. Гомдолд холбогдох эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 17 дахь заалтад “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2-т “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээний хүрээнд төрийн мэдээлэл боломжит дээд хэмжээнд ил тод байх, зөвхөн хуулиар тогтоосон онцгой нөхцөлд мэдээллийг хязгаарлах зарчим үйлчилдэг.

Сонгууль бол иргэд төрийг удирдах эрхээ шууд хэрэгжүүлэх үндсэн арга хэлбэр бөгөөд сонгуулийн үйл явц ил тод, хуулийн дагуу явагдсан эсэхийг иргэний нийгэм хянах боломжтой байх нь ардчилсан ёс, шударга ёсны баталгаа юм. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлд сонгуулийн зардлын тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байх зарчмыг хуульчилсан. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3-т улс төрийн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивыг төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан; нэр дэвшигч, нам, эвсэл авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг өөрийн байгууллагын цахим хуудаст ил тавьж, нийтэд чөлөөтэй танилцах бололцоо олгох, 58.5-т шаардсан тохиолдолд холбогдох иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл, баримтыг гаргаж өгөх төрийн аудитын дээд байгууллагын үүргийг хуульчилжээ. Мөн Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-т нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэх, 53.3-т шаардсан тохиолдолд холбогдох иргэн, хуулийн этгээд мэдээлэл, баримтыг гаргаж өгөх танай байгууллагын үүргийг заасан байна.

Төрийн аудитын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т “Төрийн аудитын байгууллага хүсэлт гаргасан этгээдэд төрийн болон байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг хуульд заасан журмын дагуу өгч болно” гэж заажээ. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.22-т “хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл”-ийг мэдээлэл хариуцагч байнга ил тод, нээлттэй байлгана. Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-ын 237 дугаарт сонгуулийн зардлын нэгдсэн тайланг Сонгуулийн Ерөнхий Хороонд харьяалагдах, тухай бүр ил байх нээлттэй өгөгдөл гэж тогтоожээ.

Сонгуулийн зардлын эцсийн тайланг бүхэлд нь ил болгохыг холбогдох хууль тогтоомжид үгчилж заагаагүй (шууд ил болгох энэ төрлийн мэдээллийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд “сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайлан”, Нээлттэй өгөгдлийн жагсаалтад “сонгуулийн зардлын нэгдсэн тайлан” гэх байдлаар нэрлэж, агуулгыг тодорхойлоогүй) боловч энэ мэдээллийг олон нийтэд ил болгох, наад зах нь хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр бүрэн дүүрэн өгөх үүргийг төрийн аудитын байгууллага хүлээсэн болох нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний улс төрийн эрхийн олон улсын пакт, Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн

тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн зохицуулалт, зарчмаас ойлгогдож байна.

Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2-т зааснаар төрийн байгууллага нь хүний хувийн мэдээллийг хуульд заасан үндэслэлээр цуглуулж, боловсруулна. Сонгуулийн зардлын тайланг хүлээн авах, хянах, нийтийн эрх ашигт хамаарах зарим мэдээллийг олон нийтэд ил болгох нь төрийн аудитын байгууллагын чиг үүрэг юм. Төрийн аудитийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т хүсэлт гаргасан этгээдэд төрийн болон байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг хуульд заасан журмын дагуу өгөх төрийн аудитын байгууллагын үүргийг заасан бөгөөд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12-т заасны дагуу хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг “хүний эмзэг мэдээлэл” гэж тодорхойлжээ. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын найм ба есдүгээр маягтад тусгасан, танай байгууллагаас нийтэд бүрэн ил болгоогүй баримтын огноо, нэр, харилцагчийн нэр, гүйлгээний утга, иргэн, хуулийн этгээдийн мөнгөн, мөнгөн бус хандив, сурталчилгааны материалын зардал, сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал, цахим орчин, радио, телевиз ашиглах зардал зэрэг мэдээлэл хүний эмзэг мэдээлэл биш юм. Харин эдгээр мэдээлэл нь сонгуулийг хуулийн дагуу санхүүжүүлсэн эсэхийг хянахад ач холбогдолтой мэдээлэл байна.

Сонгуулийн үйл ажиллагаанд хандив өгсөн болон үйлчилгээ үзүүлсэн этгээдийн нэр, хэн болохыг тодорхойлох мэдээлэл нь хүний хувийн мэдээлэл мөн боловч сонгуулийг ил тод, хуулийн дагуу явуулах, төрийг удирдах эрхийг хэрэгжүүлэх үйл явцыг олон нийт хянах боломжтой байх, улмаар Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгыг хангах нийтийн эрх ашгийн үүднээс ил болгох нь хүний эрхийг зөрчихгүй.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “мэдээлэл ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх” зарчмыг тогтоож, 15 дугаар зүйлийн 15.4-т “Мэдээлэл хариуцагч тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, хуулиар нээлттэй, ил тод байлгах мэдээллийг хүн, хуулийн этгээдэд тэдгээрийн хүсэлтийг үндэслэн бүрэн гүйцэд, үнэн зөв, тодорхой өгнө” гэж заажээ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “хүсэлт гаргагч мэдээлэл авах эрхээ хөндөгдсөн гэж үзвэл Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргаж болно” гэж, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т “хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс мэдээлэл хариуцагчид зөвлөмж өгч болно” гэж заасныг мөн дурдах нь зүйтэй.

Гурав. Дүгнэлт, шаардлага

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн

сонгуулийн зардлын тайланг “Бодлогод залуусын хяналт” НҮТББ-т холбогдох маягтад тусгагдсаны дагуу бүрэн өгөөгүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 17 дахь заалт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар баталгаажуулсан мэдээлэл авах эрхийг зөрчсөн байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 27 дугаар зүйлийн 27.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3, 24.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд хүний эрхийн зөрчлийг зогсоох зорилгоор дараах арга хэмжээ авахыг шаардаж байна. Үүнд:

1. Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын эцсийн тайланг “Сонгуулийн зардлын дансны гүйлгээ тус бүрээр хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан”, “Сонгуулийн зардлын дансны гүйлгээ тус бүрээр хийсэн зарлагын дэлгэрэнгүй тайлан” маягтуудын дагуу “Бодлогод залуусын хяналт” НҮТББ-д бүрэн гүйцэд өгөх.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй” гэж заасан. Шаардлагыг хэрэгжүүлсэн талаарх мэдээллээ баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

Хувийг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран танаа

ГИШҮҮН



Г.НАРАНТУЯА